



## ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 1738

Чингис хот

### Хязгаарлалтын дэглэмд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн сумын Сариг 4 дүгээр багт оношлогдсон гахайн африкийн мялзан өвчний хорио цээрийн дэглэмийг 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2. Гахайтай иргэдийг байнгын мэдээллээр хангаж, өвчний шинж тэмдэг шинээр илэрсэн тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагуудад шуурхай мэдэгдэж ажиллахыг Мал эмнэлгийн Улсын байцаагч (Д.Сандагдорж)-д үүрэг болгосугай.

3. Голомтын болон сэжигтэй бүсийн айл өрхүүдийн гахайд үзлэг тандалт, халдваргүйтгэлийн ажлыг хийж ажиллахыг "Абока" мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч (Ж.Амгалан)-д даалгасугай.

4. Голомтын болон сэжигтэй бүсээр дайран өнгөрч буй хүн, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Лхагвабаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ЭРДЭНЭБААТАР